



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ ТӨҮГ-ЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2025/53/НА-СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Улаанбаатар хот
2025 он

Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Энхдалай
Утас: 260512 Цахим хаяг: enkhdalai.d@audit.gov.mn
Ахлах аудитор: Ц.Энхжаргал
Утас: 261628 Цахим хаяг: enkhjargalts@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК
Захирал А.Сарангэрэл Утас: 99884842
Цахим хаяг: Gereltekhburtgelaudit3@gmail.com



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ
ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ Д.ОЮУНБОЛД
ТАНАА

2025.03.28 № 07/1274
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай 8.9.8-д заасны дагуу Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг санхүүгийн байдал болон орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Зам тээвэр хөгжлийн төв ТӨҮГ нь тайлант 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй нийт 975.6 сая төгрөгийн төсөв өртөгтэй 31 төсөл арга хэмжээнд техник технологийн хяналтын ажлыг гүйцэтгэж, 167.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл, арга хэмжээг бүрэн гүйцэтгэж дууссан, 808.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 23 төсөл, арга хэмжээ он дамжин хэрэгжиж байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

ТӨБЗГ-ын 2018 оны 289 дүгээр тогтоолоор татан буулгасан Авто замын тоног төхөөрөмж түрээс ТӨХК-ийн 5 аж ахуйн нэгж, байгууллага, 19 хувь хүнд өгөх 74.4 сая төгрөгийн өглөгийг төлж барагдуулах, 4 байгууллагаас авах 191.1 сая төгрөгийн авлагыг

шаардах эрхийг шилжүүлсэн, авлагыг барагдуулах асуудлыг шүүхээр шийдвэрлүүлж, өглөгийг барагдуулах ажлыг эзэн холбогдогчийг олж тогтоох ажлыг зохион байгуулснаар 71.9 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд Булган аймгийн Хялганат-Хангал чиглэлийн 10 км хатуу хучилттай авто зам, Архангай аймгийн Хайрхан сумын Хануйн голын 109.15 у/м төмөр бетон гүүрийн барилгын ажил, Хэнтий аймгийн Өндөрхаан-Норовлин чиглэлийн Багц-1-ийн 18.6 км зам, Багц-2-ын 20 км зам болон гүүр, Ховд аймгийн Дөргөн сумын 1.1 км зам, Ховд-Алтай чиглэлийн авто замаас Чандмань сум хүртэлх 56.9 км замын сүүлийн 25.9 км зам, Улаанбаатар-Хэнтий аймгийн Чингис хот чиглэлийн авто замаас Өмнөдэлгэр сум хүртэлх 52.5 км зам, гүүрийг улсын байнгын ашиглалтад оруулсан байна.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 94 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 96.4 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

